



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2003 оны 6 сарын 17 өдөр

дугаар 256

Улаанбаатар хот

ДҮРЭМ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ


Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг.Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дүрмийг нэгдүгээр, тус хэлтсийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр.Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх хэлтэс /Д.Батбаатар/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

 М.ЭНХБОЛД

0200654

НИЙСЛЭЛИЙН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл:

1.1. Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн Зорилго нь: Нийслэлийн нутаг дэвсгэрт Галын аюулгүй байдлын болон Ой хээрийг түймрээс хамгаалах тухай Монгол улсын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гарсан гал түймрийг унтраах замаар татвар төлөгч иргэдийн амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангуулахад оршино.

1.2. Гал Түймэртэй Тэмцэх Хэлтэс нь Нийслэлийн Засаг Даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь тогтоосон журмаар үйлдсэн, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЁР. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн удирдлага Зохион байгуулалт

2.1. Гал Түймэртэй Тэмцэх Хэлтэс нь Гал унтраах тасаг, Хяналтын тасаг, Хүний нөөц, сургалт арга зүйн алба, Санхүү аж ахуйн албатай байна.

2.2. Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гал түймэртэй Тэмцэх газрын дарга томилно.

2.3. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн даргад зөвлөх эрхтэй хэлтсийн даргын орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг хэлтсийн дарга батална.

2.4. Хэлтсийн дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжинд нийцүүлэн зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу тушаал гаргаж биелэлтийг нь хангахаас гадна улирсан алба хаагчдыг ажилд шууд томилж чөлөөлнө.

2.5. Орон тоо, цалингийн санг Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээг үндэслэн Нийслэлийн засаг дарга баталж, Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн дарга мөрдөж ажиллана.

ГУРАВ. Хэлтсийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1. Гал Түймэртэй Тэмцэх Хэлтэс нь Нийслэлийн нутаг дэвсгэрт Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх.

3.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт гарсан ой хээрийн болон объектын гал түймрийг унтраах.

3.3. Галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг харъяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах.

3.4. Хэлтсийн алба хаагчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. Хэлтсийн эрх үүрэг

4.1. Гал Түймэртэй Тэмцэх Хэлтэс нь Нийслэлийн нутаг дэвсгэрт хуулиар хүлээлгэсэн дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ.

А. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулах

Б. Объектын болон ой хээрийн гал түймрийг шуурхай зохион байгуулан унтраах

В. Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих

Г. Аж ахуйн нэгж байгууллага албан тушаалтан иргэдэд галын хэргийн анхан шатны мэдлэг олгох, гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгслийг ашиглах талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа хийх.

а/ Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах.

б/ Аж ахуйн нэгж, байгууллага дээр гал унтраах дасгал сургууль, 3, 7, 14 хоног сарын сэдэвт ажлуудыг явуулах.

в/ Хороодын иргэдийн дунд өдөрлөг, үзүүлэх сургууль зохион байгуулах.

г/ Галын аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага сурталчилгааны материалаар хангах.

д/ Аж ахуйн нэгж байгууллага, хороодын галын сайн дурын туслах хүчнийг мэргэжлийн удирдлагаар хангах.

Д. Хэлтсийн даргын ажлын хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээр хянуулж байх.

Е. 14 хоног тутам хэлтсээс зохион байгуулсан ажлын мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байх.

4.2. Нийслэлийн Гал Түймэртэй Тэмцэх Хэлтэс дор дурьдсан эрх эдэлнэ.

А. Гал унтраах анги, салбар хэсэг байгуулах, татан буулгах зэрэглэл орон тоо, нормативыг өөрчлөх асуудлыг Нийслэлийн Засаг дарга болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гал түймэртэй тэмцэх газарт тавьж шийдвэрлүүлэх.

Б. Галын аюулгүй байдлын тухай болон ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хангуулж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

В. Томоохон гал түймрийн үед Нийслэл, дүүргийн Байнгын онцгой комисстой хамтран гал унтраах, учирч болох хохирлыг арилгах арга хэмжээ авах.

Г. Гал унтраах бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, Галын аюулаас урьдчилан сэргийлэх хэм хэмжээг тогтоож зайлшгүй шаардлагатай үед саналаа Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

Д. Гал түймрийн улсын хяналтын дүрэмд заагдсан бусад эрхийг эдлэх

ТАВ.Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дүүрэг болон бусад объектуудыг хариуцсан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх, хүлээлгээх хариуцлага

5.1.Байцаагч нь "Гал түймрийн улсын хяналтын дүрэмд заасан дараах эрхийг эдэлнэ.

А.Хяналт шалгалт хийх иргэдийн орон сууц болон объектод саадгүй нэвтрэн орох.

Б.Холбогдох байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр хот суурин газар байгууллага аж ахуйн нэгжийн галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулах, галын аюулгүй байдлын техникийн дүгнэлт гаргах зэрэгт улсын хяналтын байгууллагын инженер техникийн ажилтан, эрдэм шинжилгээ зураг төслийн байгууллагын мэргэжилтэнг татан оролцуулах.

В.Аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас гал түймрийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон баримт бичиг, мэдээ материалыг шаардан гаргуулж авах.

Г.Гал түймрийн тухай мэдээлэх, ой хээрийн болон объектын гал түймрийг унтраах, хойшлуулшгүй арга хэмжээ авахын тулд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр холбооны хэрэгслийг үнэ төлбөргүй дараалал харгалзахгүй түр ашиглах.

Д.Гал гарах бодит аюул бүрдсэн гал гарсан дохиолдолд хүний амь, эд хөрөнгийг авран хамгаалах боломжгүй гэж үзвэл иргэн аж ахуйн нэгж байгууллагын үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, техник ашиглахыг хэсэгчлэн буюу бүрмөсөн хориглох, тэдгээрээс тодорхой ажил, үйлчилгээ явуулахыг түр буюу бүрмөсөн зогсоох.

Е.Гал түймэр унтраах зорилгоор ашигладаг усны шугам сүлжээ, худаг, усан санг байнгын ажиллагаатай байлгахыг холбогдох байгууллагаас шаардах.

Ж.Хот суурин газар, ой хээрт гарсан гал түймрийг унтраах түүний үр дагаврыг арилгахтай холбогдсон хойшлуулшгүй ажилд дипломат албаны болон тусгай үйлчилгээнийхээс бусад автомашин механизм, ердийн тээврийн хэрэгслийг дайчлах.

З.Галын аюулгүйн дүрэм заавар зөрчигсөд гал түймэр тавьсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх.

И.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах.

К.Гал түймрийн хэрэг зөрчлийг шалгах галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаар явах үед хот суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих.

5.2. Байцаагч нь гал түймрийн улсын хяналтын дүрэмд зааснаар хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд "Галын аюулгүй байдлын тухай", "Ой хээрийг түймрээс хамгаалах тухай", "Захиргааны хариуцлагын тухай" хууль болон бусад хууль тогтоомжид заасан шийтгэл оногдуулж хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

6.1. Хэлтэс нь Гал түймэртэй тэмцэх асуудлаар олон улсын болон гадаад улсын адил мэргэжлийн байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллаж болно.

6.2. Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь алба хаагчдынхаа үйл ажиллагаанд дотоодын хяналт тавьж хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

6.3. Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн анги тасаг, албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гаргасан санал гомдлыг шалган шийдвэрлэнэ.

6.4. Энэ дүрмээр зохицуулагдаагүй бусад асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан Гал түймэртэй тэмцэх байгууллагын дотоод албаны болон сахилгын дүрмээр зохицуулна.



Нийслэлийн Засаг даргын 2003 оны
456/з захирамжийн 2 дугаар хавсралт

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн "Хэлэлцээр соёрхон батлах тухай" хуулиар батлагдсан "Төрийн захиргаа шинэчлэлийн зээлийн хөтөлбөр", 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан Засгийн Газрын тогтоол, Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын тушаал шийдвэрийг удирдлага болгон үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулав.

Нэг. Агуулга

Төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан болно. Үүнд:

1. Ойрын 3 жилд нийлүүлэх бүтээгдэхүүн (ажил үйлчилгээ) болон стратеги зорилт.

2. Төсвийн жилийн хугацаанд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар тэдгээрийн зардал.

3. Олон улсын бүртгэлийн стандартын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ижил үзүүлэлтээр боловсруулсан санхүүгийн төлөв буюу төсөвлөсөн баланс.

4. Ерөнхий менежерээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх болон өмчлөлийн эрхтэй холбогдсон бусад асуудлууд.

5. Төсвийн жилд гарах капитал зардал (санхүүгийн эх үүсвэртэй уялдсан)

6. Тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор улсын төсөвт орох орлого, зарлагын талаархи мэдээлэл. Өмчлөлийн зорилт, чиглэл.

Хоёр. Ерөнхий менежерийн мэдэгдэл

2003 оны санхүүгийн жилд Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт чиг үүрэг, Гал Түймэртэй Тэмцэх Газраас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд Нийслэлийн гал түймэртэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр нөлөөг сайжруулах, гал унтраах бэлтгэл бэлэн байдлын түвшинг дээшлүүлэхэд гол анхаарлаа чиглүүлэн, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын үндсэн үзүүлэлтийг өмнөх 3 жилийн дунджаас 5 хувиар ахиулж, гал

түймрийн тоо, хохирлын өсөлтийг саармагжуулах арга хэмжээг стратегийн зорилттой нийцүүлэн авч хэрэгжүүлнэ.

Эрх зүй, зохион байгуулалтын хүрээ

- Монгол Улсын Үндсэн хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
- Бусад холбогдох хууль тогтоомж

Гурав. Стратегийн үндсэн зорилтууд

3.1. Байгууллагын алсын хараа

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байгууллага аж ахуйн нэгж нийслэлийн иргэдэд үзүүлэх Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэнэ. Энэ үйлчилгээг хийхийн тулд мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлж ажлын арга барилаа сайжруулан алба хаагчдын ажлын ачааллыг нягтруулах, гал унтраах орчин үеийн техник, багаж зэвсэглэмжээр нөхөн хангах бодлого баримтлан ажиллана.

3.2. Байгууллагын эрхэм зорилго, эрхэмлэх үндсэн зарчим

Эрхэм зорилго

Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь гал түймэртэй тэмцэх замаар Үндсэн хуулиар тогтоосон хүмүүнлэг ардчилсан нийгэмд бүх иргэд амьд явах, аюулгүй орчинд амьдрах, бололцоог хангах, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн галын аюулгүй байдлыг хангуулан нийслэлийн эдийн засгийн хөгжлийг тогтворжуулахад чиглэгдэнэ.

Эрхэмлэх үндсэн зарчим

а. Үйлчилгээ хүртээмжтэй байх зарчим

Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн хараа хяналтын гадна нэг ч байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх байх ёсгүй гэсэн зарчмыг удирдлага болгон ажиллана.

б. Найдвартай бэлэн байх зарчим

Гал унтраах ангиудын гал унтраах бэлтгэл бэлэн байдлын түвшинг 90-ээс доошгүй хувийн түвшинд хүргэнэ.

в. Хариуцлага хүлээх ёс

Гал Түймэртэй Тэмцэх Хэлтсийн нийт бие бүрэлдэхүүн төр иргэнийхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлж, татвар төлөгч нарын галын аюулгүй байдлыг хангуулах, өргөсөн тангарагаа чин шударгаар биелүүлэхийн төлөө ажиллаж ажлын дутагдал гаргавал зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Орчны шинжилгээ

Дотоод орчин (давуу болон сул тал)

Давуу тал

а) "Галын аюулгүй байдлын тухай" Монгол Улсын хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн Газрын тогтоол шийдвэр нь тус байгууллагын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг харьцангуй бүрдүүлж өгсөн.

б) Гал Түймэртэй Тэмцэх Газрыг өргөтгөн бие даасан бүтэц зохион байгуулалтад шилжүүлэн Засгийн Газрын агентлаг болгон бэхжүүлсэн.

Сул тал

а) Галын мэргэжлийн дээд боловсролтой боловсон хүчин ихээхэн дутагдалтай;

б) Гал унтраах ангиудын хэмжээнд зайлшгүй байх шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдал "Гал унтраах ангийн зэрэглэл, галын автомашины тоо" MNS5108-2001. Монгол Улсын стандартын хэмжээнд хүрээгүй;

в) Нийслэлийн хэмжээний Гал унтраах 13 ангид ашиглагдаж байгаа гал унтраах үндсэн болон тусгай зориулалтын автомашины 52,4 хувь гүйлт норм дуусч, парк шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагатай болсон;

г) Нийслэлийн хэмжээнд ой хээрийн түймэр гарах магадлал өндөртэй 7 дүүрэгт байвал зохих гал унтраах техник, багаж хэрэгслийн нөхөн хангалт шаардлагын хэмжээнд хүрэхгүй.

д) ГУ 65, 30, 18, 14, 80 дугаар ангигудын байр гараашийн зориулалт – тай байгаа нь ажил үүрэг гүйцэтгэх шаардлагын түвшингээс эрс хоцрогдсон

Гадаад орчин (Боломж ба бэрхшээл)

Боломж

а) Гал Түймэртэй Тэмцэх Хэлтэс Азийн олон улсын Галын байгууллагын дарга нарын холбоонд элссэн. Энэ чиглэлээр жил бүр зохиогддог хурал цуглаанд идэвхитэй оролцох боломж бүрдсэнээр Азийн тэргүүлэх орнуудын тусламж дэмжлэг авах нөхцөл бий болсон.

б) Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжийн хүрээнд "Улаанбаатар хотын гал унтраах техник тоног төхөөрөмж, холбооны хэрэгслийг шинэчлэн сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлж эхэлж байгаа;

в) Оросын Холбооны Улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу мэргэжлийн дээд боловсролтой боловсон хүчинг бэлтгэж эхэлсэн;

г) Гадаадын ижил төрлийн байгууллагын зардлаар алба хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах боломж нээгдсэн;

Бэрхшээл


а) Улс орны нийгэм эдийн засгийн нөхцөл боломжоос шалтгаалан гадаад оронд үйлдвэрлэсэн өндөр үнэтэй гал унтраах техник, багаж зэвсэглэмжийг худалдан авах боломж муу;

б) Хэлний хүндрэлээс шалтгаалан АНУ, Япон, Солонгос Улсад мэргэжлийн боловсон хүчин сургах боломж хомс байгаа;

в) Мэргэжлийн дээд боловсролтой боловсон хүчинг сургаж бэлтгэх зардал хэт өндөр;

Удирдлага, зохион байгуулалт

Байгууллагын бүтэц зохион байгуулалт



Хяналтын систем

Хэлтсийн удирдлага, дотоодын хяналт шалгалт хариуцсан байцаагчаас үйл ажиллагааны түвшний хяналт, удирдлагын зүгээс шийдвэр гаргах үйл явц, түүний биелэлтэд болон дүрмийн хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

Удирдлагын бүтэц, боловсон хүчний чадавхи Менежментийн үр чадвар

Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн удирдлагын бүрэлдэхүүнд 12 алба хаагч ажиллаж байна. Удирдлагад ажилладаг ажилтнууд нь төрийн албаны тангараг өргөсөн, төрийн албаны алба хаагчид тул Галын байгууллагын ажилтны ёс зүй, сахилга батын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Захиргааны зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэлтсийн хэмжээнд тулгамдсан асуудлуудыг шийдэж ажилладаг. Эзэмшсэн мэргэжил, боловсролын хувьд галын байгууллагын алба хаагчид нь нарийн мэргэжлийн мэргэшсэн байхаас гадна удирдлагын 12 алба хаагчийн 8 – нь хоёр дээд сургууль / үүнээс Удирдлагын академи – 3 / төгссөн 35 – 48 насны ажилтанууд, тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Дунд шатны удирдах ажилтнуудын хувьд / 19 / алба хаагч, голлон Цагдаагийн академийг дүүргэсэн галын техникч - хуульч мэргэжилтэй 24 – 42 насны залуучууд ажиллаж байна.

Үндсэн алба хаагчдын тоо, үр чадвар

Нийслэлийн ГТТХ – ийн нийт бие бүрэлдэхүүний судлагааг товч үзүүлбэл

	Нийт Нас				Хүйс		боловсрол		
	18-25		25-35	35-55	эр	эм	дээд	Тусгай дунд	Бүрэн дунд
Офицер	101	11	27	63	100	1	20	78	3
Улирагч	505	206	141	158	452	53	6	135	364
энгийн	20	4	5	11	3	17	1	4	15

Гал түймэртэй тэмцэх хэлтсийн бүх алба хаагчдыг жил бүр мэргэжлийн зэргийн шалгалтанд хамруулдаг, 2002 оны мэргэжлийн зэргийн шалгалтанд 2 – оос дээш жил ажилласан 587 алба хаагч хамрагдсанаас I зэргийг 58, II зэргийг 88, III зэргийг 253 алба хаагч хангаж, бие бүрэлдэхүүний 67,9 хувь нь мэргэжлийн зэрэгтэй болсон байна.

Байгууллагын өрсөлдөх чадвар

Тоо баримт : Нийслэлийн Гал унтраах ангиуд 2002 онд 1327 удаа галын дуудлагаар гарч, 901 гал дээр байлдааны тархалт хийн ажиллаж, гал түймрийн аюулаас 18 хүний амь нас, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 995,9 сая төгрөгийн өмч хөрөнгө авран хамгаалсан байна. Гарсан 1327 гал түймрийг унтраахад гал унтраах ангиуд 89228 л шатах, тослох материал, 1444 тн ус, 335 л хөөс зарцуулжээ. Мөн хотын ногоон бүсэд 35 удаа ой, хээрийн түймэр гарч 90 гаруй сая төгрөгийн нийт хохирол учруулан, түймэр унтраахад 285 алба хаагч, 16 техник ажиллажээ.

Хэрэг бүртгэгч, байцаагч нар 2002 онд гал түймэр гарсан тухай нотломж 259-г тогтоосноос хохирол ихтэй 16 хэрэгт эрүү үүсгэн шалгаж хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, галын зөрчлийн нотломж 5, галын зөрчлийн тэмдэглэл 893-г хөтөлж, нийт 1152 гал түймрийн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийслэлд гарсан 1152 гал түймрийн хэргийн улмаас 18 хүн амь насаа алдаж, төр, аж ахуйн нэгж, иргэний өмчид 1,17 тэрбум төгрөгийн хохирол учирч, гал түймэрт 429 барилга байгууламж, 426 өвөл, зуны сууц, 195 гэр, 143 машин техник тоног төхөөрөмж өртсөн байна.

Эдгээр тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал гал түймрийн хэрэг зөрчлийн тоо 13,2 хувиар, хохирол нь 76,4 хувиар тус тус өсчээ.

Хяналтын тасгийн байцаагч нар 2002 онд 3816 байгууллага, аж ахуйн нэгж, 18168 айл өрхөд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, гал гарч болзошгүй 31396 зөрчил илрүүлэн 12103 зөрчлийг шалгалтын явцад арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 770, мэдэгдэл 122, ажиллагаа зогсоох тогтоол 156, галын аюулгүйн нөхцөл байдлын талаар 83 танилцуулга тус тус бичиж холбогдох газарт нь хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өглөө.

Түүнчлэн галын аюулгүйн дүрэм зөрчсөн, гал түймрийн хяналтын байцаагчийн шаардлага биелүүлээгүй 531 байгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийг 20,05 сая төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ авсан байна.

Дээрхи тоон үзүүлэлт нь тус хэлтсээс хийдэг ажлыг харуулсан багц мэдээлэл юм. Энд бидний үйлчилгээ иргэдэд хүрч байгаа байдлыг гал түймрийн тоо, хохирлын бууралт, нэгэнт гарсан галыг хохирол багатай, шуурхай унтраах үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж удирдлагын стратеги, бодлого чиглэлтэй уялдуулна гэсэн үг юм.

Байгууллагын тоног төхөөрөмж, машин техник, барилга байгууламж

Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь гал унтраах үндсэн үүрэг бүхий Галын автомашин – 46, үйлчилгээний автомашин - 5 байна. Гал унтраах автомашин дотроо үндсэн ба тусгай гэж хуваагдана. Үндсэн Галын автомашин 39, тусгай Галын автомашин 7/. Галын автомашин нь дагалдах багаж хэрэгсэл болох шат, хошуу, хоолой, гэрэл, бусад хэрэгсэлтэй байна. Хошуу, хоолойны нөөцийг 2 жил тутам шинэчлэн, машин техникийг нормативын дагуу ашиглаж байна.

Холбооны техникийн хувьд 1980 оны БНАГУ –ын /хуучин нэрээр/ холбооны хэрэгсэлтэй байгаа нь шуурхай албаны хэвийн ажиллагаа явуулах боломжгүй болоод байна.

Машин, техникийн ашиглалтын жилийг үзүүлбэл.

№	Авто машин	Зориулалт	Нийт тоо	1980–1990	1990- 1997	1997-2001
1	Галын авто машин	үндсэн	39	31	3	5
		тусгай	7	6	0	1
2	Үйлчилгээний машин		5	0	2	3

Маркетингийн зах зээлийн хүчин чадал

Тус байгууллагын үйлчилгээг хэрэглэгч нь нийслэлийн иргэд, татвар төлөгч байгууллага, аж ахуйн нэгж байдаг.

Судалгаа, шинжилгээ

Нийслэлд гарч байгаа гал түймрийн судалгааг сүүлийн 3-5 жилээр болон сар бүрээр нарийвчлан гаргадаг. Энэ ажлыг хяналтын тасаг явуулж, сар, улирлаар нэгтгэн дүн шинжилгээ хийн галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг юунд чиглүүлэх талаар прогноз дэвшүүлнэ. Тэрчлэн ирэх 5 – 10 жилд нийслэлийн хэмжээнд гарч болох гал түймрийн урьдчилсан мэдээллийг боловсруулдаг. Мөн түүнчлэн гарсан гал түймрийн талаархи дэлгэрэнгүй танилцуулгыг Нийслэл дүүргийн Засаг дарга нар болон Хууль Зүй Дотоод Хэргийн Яаманд хагас бүтэн жилээр гарган хүргүүлж мэдээллээр хангаж байна.

Санхүүгийн нөхцөл байдал

Төсвийн орлогын эх үүсвэр

Ашгийн бус тус байгууллагын санхүүгийн байдлыг тодорхой болгохын тулд санхүүжилтийн хувиарлалтыг авч үзье. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны тогтоолоор ГТТХ –ийн төсвийг 2002 онд 721966,2 мянган төгрөгөөр баталж өгсөнөөс гүйцэтгэл нь 732895,7 мянган төгрөг гарсан байна. Үүнээс 66,2 хувийг нь цалинд олгожээ.

Хотын санхүүгээс тус хэлтсийн санхүүжилтийн 1,7 хувийг / 10 сая төгрөг / дотоод нөөц болоцоогоор бий болгохоор тооцож санхүүжилтийг хийжээ.

Төсвийн зарлага

Олгогдсон төсвөөс Нийгмийн даатгалын шимтгэл, ажил олгогчийн болон бараа, үйлчилгээний зардалд нийт төсвийн 25 орчим хувийг зарцуулжээ. Мөн тээвэр, шатах материал, сэлбэг хэрэгсэл, барилгын урсгал засвар, гэрэл, дулаан, шуудан, холбооны зардлыг оруулаад төсвийн байгууллагын санхүүжилт бүрдэж байна.

Энд ашгийн бус байгууллагын хувьд зардлыг бууруулах замаар л тодорхой үр ашигт хүрэх арга зам бий. Зардал гэдэг ойлголтод гал унтраах үеийн зардлыг хэмнэх, байгууллагын зардлыг хэмнэх зэрэгт голлон анхаарах нь зүйтэй байна. Үүнээс гадна үзүүлж буй үйлчилгээнийхээ үнийг / төлбөрт үйлчилгээ / бодитой тогтоох асуудлыг нухацтай авч үзэх шаардлагатай юм.

3.4. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн стратегийн зорилт (хүрэх үр дүн)

Гал түймэртэй тэмцэх хэлтэс 2003-2005 онд дараах үр дүнд хүрэх зорилт тавьж байна. Үүнд:

Стратегийн зорилт 1. Иргэд, татвар төлөгчдөд түргэн шуурхай, найдвартай үйлчлэн, тэдний итгэлийг олох

Стратегийн зорилт 2. Хуулиар олгогдсон эрхийн хүрээнд татвар төлөгчдийн галын аюулгүй байдлыг хангуулах үйлчилгээ үзүүлэх

Стратегийн зорилт 3. Алба хаагчдынхаа мэргэжил, мэдлэг боловсролыг нэмэгдүүлэн, байнгын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, ажлын байрны нөхцөл бололцоог сайжруулах, аюулгүй ажиллагааг хангуулах

Нийслэлийн нутаг дэвсгэрт Гал түймэртэй тэмцэх хэлтсийн үйл ажиллагаа нь дээрх стратегийн зорилтыг хангахад чиглэгдэнэ.

3.5. Ерөнхий менежерийн үйл ажиллагааны хамрах хүрээ

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон ой, хээрийн түймэр гарч болзошгүй нутаг дэвсгэрийн галын аюулгүй байдлыг хангуулах, гарсан гал түймрийг хохирол багатай түргэн шуурхай унтраахад бие бүрэлдэхүүнийг татан оролцуулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн туслалцаа авах, гал унтраах техник тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, боловсон хүчний сургалт, мэргэжлийн үр чадварыг сайжруулах зэрэг иж бүрэн арга хэмжээ багтана.

3.6. Хэлтсээс нийлүүлэх бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний ангийн жагсаалт

Бүтэгдээхүүний анги: 1. Нийслэлд гарсан объектын болон Ой хээрийн түймэр унтраах.

Бүтээгдэхүүн 1.1 - Гарсан гал түймрийг унтраах үйлчилгээ

Томъёолол:

Нийслэл хотын хэмжээнд гарч байгаа гал түймрийг байгаа хэмжээнд нь тактикийн алдаагүй, техникийн сааталгүй, цаг алдалгүй унтраах үйл ажиллагаа зохион байгуулна.

Шалгуур үзүүлэлт	2003 онд хүрэх түвшин	Бүтээгдэхүүний өртөг зардал
1. Нийслэл хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 13 гал унтраах ангийн байлдааны бэлэн байдлыг хангуулах	Гал унтраах бэлтгэл бэлэн байдлын түвшинг 90 хувьд хүргэнэ .	467259.7

Бүтээгдэхүүний анги 2- Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжинд хяналт тавих.

Томъёолол

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд гал гарч байгаа шалтгаан нөхцөлийн байдалд дүн шинжилгээ хийж, гал түймрийн тоо хохирлын өсөлтийг саармагжуулах бодлого баримтлана.

Бүтээгдэхүүн 2.1 - Галын аюулаас урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх:

Шалгуур үзүүлэлт	2003 онд хүрэх түвшин	Бүтээгдэхүүний өртөг зардал.
Тоо хэмжээ Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтын тоо -2100 Хамрагдах объект - 3553 айл өрх - 22550 Бичсэн Заавал биелүүлэх албан шаардлага - 836 Танилцуулга- 16 Мэдэгдэл - 50 Ухуулга яриа хийх байгууллага аж ахуйн нэгж - 330 Сурталчилгаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл- 108 удаа	Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын дундаж үзүүлэлтийг өмнөх 3 жилийн дундажаас 5 хувиар ахиулах	229378.9

Дээрх тоон үзүүлэлтийг хэлтсийн сүүлийн 3 жилийн дундаж үзүүлэлтийг 5 хувиар ахиулан тооцсон болно.

Бүтээгдэхүүний анги 3 - Бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдал, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх. , сургалт явуулах.

Томъёолол


Алба хаагчдын мэргэжлийн болон байгууллага аж ахуйн нэгж иргэдийн галын хэргийн мэдлэгийг дээшлүүлэх.

Шалгуур үзүүлэлт	2003 онд хүрэх түвшин	Бүтээгдэхүүний өртөг, зардал
Тоо хэмжээ 1.Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн нийт бие бүрэлдэхүүнд зохион байгуулах мэргэжлийн хичээл 3 шатны сургалт Үүнд: -Өдөр тутмын сургалт - 4368 -Салаа ээлжийн тархалтын сургууль - 624 -Гал унтраах ангийн тактикийн сургууль-52 2.Байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн галын хэргийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалт	Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшилнэ. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн галын хэргийн мэдлэг сайжирч гал гарах магадлал багасна.	56198.5

Тусгай захиалгат:

Бүтээгдэхүүн 1 Гал унтраах машин техник, багаж зэвсэглэмжээр хангах.

Шалгуур үзүүлэлт	2003 онд хүрэх түвшин	Бүтээгдэхүүний өртөг, зардал
1.Япон улсын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн хэмжээнд Гал унтраах 17 үндсэн болон тусгай зориулалтын гал унтраах автомашин холбооны хэрэгслээр хангагдана.	Гал унтраах бэлтгэл бэлэн байдлын түвшин дээшилнэ.	7.2 сая ам доллар



4. Төсвийн жилд нийлүүлэх бүтээгдэхүүн анги тус бүрээр :

5. Нийслэлийн Төсвийн Ерөнхийлөн захирагчтай нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн байгуулсан гэрээний хавсралт № 2

Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсээс гэрээний дагуу нийлүүлсэн бүтээгдэхүүний төлбөрийг шилжүүлэх хуваарь

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Төрийн сангийн хэлтэс дахь дансны дугаар № -----

Бүтээгдэхүүн нийлүүлэгч Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дансны дугаар № -----

/ мянган төгрөг /

№	Санхүүжилтийн нэр агуулга,	2003 оны сар, улирал	Олгох санхүүжилт
1	Урсгал санхүүжилт	1-р сар 2-р сар 3-р сар	79161.6 77114.5 79873.2
		Улирлын дүн	236149.3
		4-р сар 5-р сар 6-р сар	78652.2 72635.2 69830.9
		Улирлын дүн	221118.3
		7-р сар 8-р сар 9-р сар	54782.2 54644.6 58072.4
		Улирлын дүн	167499.2
		10-р сар 11-р сар 12-р сар	55411.8 55400.3 17258.2
		Улирлын дүн	128070.3
	ДҮН	Жилийн дүн	752837.1

6. Өмчлөлийн бусад зорилт, чиглэл

6.1. Нөөцийн ашиглалт сайжруулалт

6.1.1. Хүний нөөц

Байгууллагын алба хаагчдын тоо: 626

Боловсон хүчний талаар баримтлах бодлого нь: Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ажилтан нь мэргэжлийн, төрийн албаны / Гал түймэртэй тэмцэх байгууллагын ажилтны / тангараг өргөсөн, 18 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдрын шаардлага хангасан Монгол улсын иргэн байхаар хуульд заасан. Боловсон хүчнийг сонгон

шалгаруулахдаа тусгай дамжаа төгсгөөд 6 сар хүртэл дадлагажих ажилтнаар томилон ажиллуулж байгаад жинхлэх талаар хэлэлцдэг. Гал сөнөөгчөөс эхлэн бүх шатны алба хаагчид 2 жилд нэг удаа мэргэжлийн зэргийн шалгалтад хамрагдаж, жил бүр батлагдсан хөтөлбөрийн дагуу мэргэжлийн хичээлд хамрагдана.

Цалин урамшууллыг хөдөлмөрийн үр дүнтэй нь уялдуулах: Алба хаагчдыг ажил мэргэжилтэй нь уялдуулан сарын ажлын дундаж үзүүлэлтийг батлан гаргаж тэрхүү үзүүлэлтийг биелүүлж байгаа байдалд сар бүр үнэлгээ өгч тохирох цалинг олгон ажиллаж байна.

6.1.2. Биет хөрөнгийн нөөц.

Өмчлөлийн зорилтыг тодорхойлох ба сонгох

Тус байгууллага нь төсвийн хөрөнгийг

- Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа
- Сургалт зохион байгуулах
- Материаллаг бааз, хангалт үйлчилгээ
- Гал унтраах автомашины засвар, үйлчилгээ, холбоо, зэвсэглэмжийн нөхөн хангалтанд зориулна.

2003 оны санхүүгийн жилд төсвийн санхүүжилт урсгал зардалд 752637,1 мянган төгрөгөөр баталлаа. Төсвийг батлагдсан хууль тогтоомжийн дагуу үр ашигтай бүрэн дүүрэн ашиглах зорилттой ажиллана.

Тус байгууллагын өмчлөлийн харилцааг Нийслэлийн өмчийн харилцааны газар хариуцна.

Тус хэлтэс 258213950,6 төгрөгийн үндсэн хөрөнгө эзэмшиж байна.

6.2. Эрсдэл.

Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө: Ой хээрийн түймэр, томоохон гал түймэр дээр төлөвлөгдөөгүй өр төлбөр бий болох машин техникийн хохирол амсах болон гал сөнөөгчид нь амь нас, эрүүл мэндээр хохирох эрсдэлтэй.

6.3. Улсын хөрөнгө, өр төлбөр ба орлого, зарлага

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ажлын онцлоготой холбоотой болохоор энэ бүлэгт тодорхой бичих зүйлгүй.

Хэлтсийн нийт хөрөнгө жилийн эд хөрөнгийн тооллогоор баталгаажина.

Өр төлбөр: Одоогийн байдлаар өр төлбөр байхгүй.